

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжил политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/19/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Ц.Азжая
Утас: 70432545
цахим хаяг: Azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/.....	4
2.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/.....	9
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Зөвлөмж	16
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	17



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХӨГЖИЛ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.БАЯРМАА ТАНАА

2022.02.25 № 2/91
танай -ны № -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Хөгжил политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Хөгжил политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

НА Нотлох ажил
ХНХЯ Хөдөлмөр нийгэм хамгааллын яам

1.Аудитын санал дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	192,699,657.0	164,975,869.0
33	АВЛАГА	61,747,266.0	52,705,760.0
335	Бусад авлага	61,747,266.0	52,705,760.0
3351	Байгууллагаас авах авлага	5,859,106.0	00.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	55,888,160.0	52,705,760.0
34	УРЬДЧИЛГАА	25,208,347.0	00.0
3471	Урьдчилгаа тооцоо	25,208,347.0	00.0
34713	Цалингийн урьдчилгаа	25,208,347.0	00.0
35	БАРАА МАТЕРИАЛ	105,744,044.0	112,270,109.0
351	Түүхий эд материал	2,680,680.0	2,639,680.0
35130	Эм боох материал	2,680,680.0	2,639,680.0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,249,600.0	7,315,600.0
354	Хангамжийн материал	74,043,764.0	77,914,829.0
35410	Бичиг хэргийн материал	1,829,100.0	1,437,800.0
35420	Аж ахуйн материал	6,857,800.0	4,388,400.0
35450	Барилгын засварын материал	22,500.0	22,500.0
35460	Хүнсний материал	387,000.0	1,032,440.0
35470	Бусад хангамжийн материал	64,947,364.0	71,033,689.0
35600	Мал амьтад	20,770,000.0	24,400,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,943,405,268.3	6,393,923,092.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,943,405,268.3	6,393,923,092.7
392	Биет хөрөнгө	3,416,699,768.3	3,867,217,592.7
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,919,020,828.5	3,553,665,298.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	-434,126,539.0	-651,444,338.8
39203	Авто-гээврийн хэрэгсэл	49,011,728.5	49,011,728.5
39204	Хуримтлагдсан элэгдэл	-41,345,061.8	-48,511,728.5
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,804,159,782.3	3,067,640,225.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	1,988,815,067.6	2,223,714,401.3
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	217,408,712.3	303,637,575.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	-181,960,866.0	-268,607,985.1
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,974,871.8	4,974,871.8
39215	Хуримтлагдсан элэгдэл	-134,871.8	-134,871.8
39217	Ном	68,506,251.1	80,701,218.2

393	Биет бус хөрөнгө	2,526,705,500.0	2,526,705,500.0
39301	Програм хангамж	29,325,017.8	30,095,017.8
39302	Хуримтлагдсан элэгдэл	-29,325,017.8	-30,095,017.8
39303	Бусад биет бус хөрөнгө	2,526,705,500.0	2,526,705,500.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,136,104,925.3	6,558,898,961.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,719,701.0	00.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,719,701.0	00.0
413	Өглөг	6,719,701.0	00.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,859,106.0	00.0
4136	Бусад өглөг	860,595.0	00.0
41361	Байгууллагад төлөх өглөг	779,745.0	00.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	80,850.0	00.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,129,385,224.3	6,558,898,961.7
51	Засгийн газрын хувь оролцоо	6,129,385,224.3	6,558,898,961.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,198,672,137.0	5,198,672,137.0
51101	Өмч: - төрийн	5,198,672,137.0	5,198,672,137.0
512	Хуримтлагдсан үр дүн	-563,702,020.4	-134,188,283.0
51210	Өмнөх үеийн үр дүн	-563,702,020.4	-566,884,420.4
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	432,696,137.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,494,415,107.7	1,494,415,107.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,136,104,925.3	6,558,898,961.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
01.0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,069,556,362.9	4,132,846,945.8
12.0	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,055,490,347.9	4,047,053,452.8
120.0	Нийтлэг татварын бус орлого	1,421,443,247.9	1,088,738,252.8
120,004.0	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,421,443,247.9	1,088,738,252.8
1,200,041.0	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,836,807.0	14,131,340.0
1,200,045.0	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,395,606,440.9	1,074,606,912.8
122.0	Тусламжийн орлого	2,634,047,100.0	2,958,315,200.0
13.0	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,066,015.0	85,793,493.0
1,311.0	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,015,550.0	85,793,493.0
131,101.0	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,760,000.0	65,394,413.0
131,104.0	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.0	15,407,200.0
131,105.0	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,255,550.0	4,991,880.0
1,340.0	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	50,465.0	00.0
134,001.0	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	50,465.0	00.0
02.0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,279,337,101.0	3,684,844,568.4
21.0	УРСГАЛ ЗАРДАЛ	3,279,337,101.0	3,684,844,568.4

210.0	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,030,534,338.0	3,420,822,769.0
2,101.0	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,702,584,864.1	1,852,559,271.7
210,101.0	Үндсэн цалин	1,175,654,349.1	932,164,704.0
210,102.0	Нэмэгдэл	474,235,618.0	789,277,031.7
210,103.0	Унаа хоолны хөнгөлөлт	13,394,897.0	63,443,221.0
210,104.0	Урамшуулал	39,300,000.0	67,674,315.0
2,102.0	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209,729,428.9	238,556,490.9
210,201.0	Тэтгэврийн даатгал	172,244,817.5	167,400,139.4
210,202.0	Тэтгэмжийн даатгал	7,174,745.8	18,506,092.1
210,203.0	ҮОМШӨ-ний даатгал	5,739,795.3	14,784,713.4
210,204.0	Ажилгүйдлийн даатгал	1,358,579.4	3,426,817.5
210,205.0	Эрүүл мэндийн даатгал	23,211,490.9	34,438,728.5
2,103.0	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	317,767,627.0	398,559,110.0
210,301.0	Гэрэл, цахилгаан	25,177,947.0	19,036,825.0
210,302.0	Түлш, халаалт	240,950,560.0	311,034,785.0
210,303.0	Цэвэр, бохир ус	51,639,120.0	68,487,500.0
2,104.0	Хангамж, бараа материалын зардал	52,112,459.0	60,301,560.0
210,401.0	Бичиг хэрэг	4,320,891.0	2,354,998.0
210,402.0	Тээвэр, шатахуун	6,371,400.0	8,151,350.0
210,403.0	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,339,145.0	4,774,437.0
210,405.0	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,334,300.0	3,271,563.0
210,406.0	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,476,723.0	20,979,212.0
210,407.0	Аж ахуйн материал худалдан авах зардал	20,270,000.0	20,770,000.0
2,105.0	Нормативт зардал	22,701,244.0	67,235,522.0
210,501.0	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,180,396.0	1,745,500.0
210,502.0	Хоол, хүнс	15,776,348.0	60,357,622.0
210,503.0	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,744,500.0	5,132,400.0
2,106.0	Эд хогшил, урсгал засварын зардал	22,286,350.0	19,871,000.0
210,601.0	Багаж, техник, хэрэгсэл	1,415,000.0	2,438,900.0
210,603.0	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,756,000.0	1,393,000.0
210,604.0	Урсгал засвар	18,115,350.0	16,039,100.0
2,107.0	Томилолт, зочны зардал	1,293,200.0	768,000.0
210,702.0	Дотоод албан томилолт	1,293,200.0	768,000.0
2,108.0	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,327,928.0	76,774,420.0
210,801.0	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,608,480.0	69,129,040.0
210,802.0	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,699,600.0	6,804,100.0
210,803.0	Даатгалын үйлчилгээ	646,600.0	646,600.0
210,804.0	Тээврийн хэрэгслийн татвар	131,000.0	116,680.0
210,805.0	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.0	78,000.0
210,807.0	Газрын төлбөр	1,989,248.0	00.0
2,109.0	Бараа үйлчилгээний бусад зардал	670,731,237.0	706,197,394.4
210,901.0	Бараа үйлчилгээний бусад зардал	37,576,650.0	6,386,800.0
210,902.0	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,229,608.9	149,249,235.0
210,903.0	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	550,924,978.1	550,561,359.4
213.0	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248,802,763.0	264,021,799.4

2,132.0	Бусад урсгал шилжүүлэг	146,867,465.0	254,359,000.0
213,202.0	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	50,465.0	00.0
213,207.0	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	70,656,300.0	135,396,100.0
213,208.0	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	73,710,400.0	117,472,900.0
213,209.0	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,450,300.0	1,490,000.0
2,133.0	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,935,298.0	9,662,799.4
213,303.0	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,935,298.0	9,662,799.4
03.0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	790,219,261.9	448,002,377.4
225.0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.0	15,306,240.0
225,005.0	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.0	15,306,240.0
04.0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.0	-15,306,240.0
05.0	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	790,219,261.9	432,696,137.4

2.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,620,824,548.0	3,841,456,302.8	-1,594,468,237.9	18,867,812,612.9
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,620,824,548.0	3,841,456,302.8	-1,594,468,237.9	18,867,812,612.9
C07	Тайлант үеийн үр дүн	-960,000.0	00.0	-57,173,719.0	-58,133,719.0
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,198,672,137.0	1,494,415,107.7	-563,702,020.4	6,129,385,224.3
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,198,672,137.0	1,494,415,107.7	-563,702,020.4	6,129,385,224.3
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	-3,182,400.0	-3,182,400.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,198,672,137.0	1,494,415,107.7	-566,884,420.4	6,126,202,824.3
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	432,696,137.4	432,696,137.4
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,198,672,137.0	1,494,415,107.7	-134,188,283.0	6,558,898,961.7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,674,100,042.0	3,085,770,340.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,986,927.0	36,172,940.0
120	Нийтлэг татварын бус орлого	25,986,927.0	36,172,940.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,836,807.0	36,172,940.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,836,807.0	36,172,940.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,648,113,115.0	3,049,597,400.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,634,047,100.0	2,958,315,200.0

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,634,047,100.0	2,958,315,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,015,550.0	91,282,200.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,760,000.0	66,195,800.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,407,200.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,255,550.0	9,679,200.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,674,100,042.0	3,085,770,340.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,674,100,042.0	3,085,770,340.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,425,297,279.0	2,821,738,540.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,709,765,150.9	1,814,129,594.7
210101	Үндсэн цалин	1,059,455,091.1	1,026,893,592.0
210102	Нэмэгдэл	542,217,309.6	663,104,173.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46,303,095.0	57,182,960.0
210104	Урамшуулал	61,789,655.2	66,948,869.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209,725,880.1	240,785,370.9
210201	Тэтгэврийн даатгал	172,241,268.7	169,645,844.4
210202	Тэтгэмжийн даатгал	7,174,745.8	18,501,892.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,739,795.3	14,781,352.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,358,579.4	3,425,977.5
210205	Эрүүл мэндийн даатгал	23,211,490.9	34,430,304.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	317,767,627.0	410,759,110.0
210301	Гэрэл, цахилгаан	25,177,947.0	19,036,825.0
210302	Түлш, халаалт	240,950,560.0	323,234,785.0
210303	Цэвэр, бохир ус	51,639,120.0	68,487,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	30,168,512.0	35,208,149.0
210401	Бичиг хэрэг	2,772,790.0	1,987,695.0
210402	Тээвэр, шатахуун	6,371,400.0	11,868,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,318,245.0	4,841,534.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,359,400.0	5,296,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,346,677.0	11,214,420.0
2105	Нормативт зардал	19,184,296.0	76,649,810.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,127,396.0	1,709,100.0

210502	Хоол, хүнс	12,088,500.0	69,803,810.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,968,400.0	5,136,900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,495,400.0	21,354,800.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,798,000.0	5,239,000.0
210602	Тавилга	-	3,564,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,756,000.0	2,228,000.0
210604	Урсгал засвар	17,941,400.0	10,323,800.0
2107	Томилолт, зочны зардал	1,293,200.0	768,000.0
210702	Дотоод албан томилолт	1,293,200.0	768,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,281,528.0	99,216,530.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,608,480.0	91,571,150.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,653,200.0	6,804,100.0
210803	Даатгалын үйлчилгээ	646,600.0	646,600.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,000.0	116,680.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	253,000.0	78,000.0
210807	Газрын төлбөр	1,989,248.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,615,685.0	122,867,176.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,016,900.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,615,685.0	110,850,276.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248,802,763.0	264,031,799.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,867,465.0	254,369,000.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	50,465.0	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	70,656,300.0	135,396,100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	73,710,400.0	117,472,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,450,300.0	1,500,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	101,935,298.0	9,662,799.4
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	101,935,298.0	9,662,799.4
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,994,315,200.0	2,984,825,340.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,994,315,200.0	2,984,825,340.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,739,485,900.0	2,730,456,340.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,815,447,300.0	1,814,129,594.7
210101	Үндсэн цалин	1,068,262,300.0	1,026,893,592.0
210102	Нэмэгдэл	601,551,600.0	663,104,173.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,429,000.0	57,182,960.0
210104	Урамшуулал	79,204,400.0	66,948,869.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,051,200.0	240,785,370.9
210201	Тэтгэврийн даатгал	175,570,000.0	169,645,844.4
210202	Тэтгэмжийн даатгал	17,120,300.0	18,501,892.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,696,200.0	14,781,352.9
210204	Ажилгүйдлийн даатгал	3,424,100.0	3,425,977.5
210205	Эрүүл мэндийн даатгал	34,240,600.0	34,430,304.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	414,214,100.0	410,759,110.0
210301	Гэрэл, цахилгаан	22,728,800.0	19,036,825.0
210302	Түлш, халаалт	323,302,800.0	323,234,785.0
210303	Цэвэр, бохир ус	68,182,500.0	68,487,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,611,900.0	29,611,149.0
210401	Бичиг хэрэг	1,893,600.0	1,893,595.0
210402	Тээвэр, шатахуун	5,252,300.0	6,365,100.0
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	5,905,200.0	4,841,534.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,266,500.0	5,296,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,294,300.0	11,214,420.0
2105	Нормативт зардал	76,650,800.0	76,649,810.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,709,100.0	1,709,100.0
210502	Хоол, хүнс	69,804,800.0	69,803,810.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,136,900.0	5,136,900.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,865,400.0	15,689,800.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,312,000.0	3,138,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,229,600.0	2,228,000.0
210604	Урсгал засвар	10,323,800.0	10,323,800.0
2107	Томилолт, зочны зардал	772,200.0	768,000.0
210702	Дотоод албан томилолт	772,200.0	768,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,536,400.0	41,727,380.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,471,400.0	34,082,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,075,000.0	6,804,100.0
210803	Даатгалын үйлчилгээ	646,600.0	646,600.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,400.0	116,680.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.0	78,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,336,600.0	100,336,126.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,450,000.0	8,450,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	91,886,600.0	91,886,126.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	254,829,300.0	254,369,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	254,829,300.0	254,369,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	135,396,200.0	135,396,100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	117,472,900.0	117,472,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,960,200.0	1,500,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,994,315,200.0	2,984,825,340.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,958,315,200.0	2,984,825,340.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,958,315,200.0	2,984,825,340.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	36,000,000.0	36,172,940.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,000,000.0	36,172,940.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	120.0	125.0
620001	Удирдах ажилтан	4.0	4.0
620002	Гүйцэтгэх ажилтан	88.0	91.0
620003	Үйлчлэх ажилтан	28.0	30.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,029.0	1,029.0

632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	1,029.0	1,029.0
632001	Төрийн өмчит МСҮТ	1,029.0	1,029.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	120.0	125.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	88.0	88.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32.0	37.0

2.6 Аудит хийсэн нэмэлт гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,582,270.0	91,282,200.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,582,270.0	91,282,200.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,582,270.0	91,282,200.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,854,000.0	-
210101	Үндсэн цалин	1,854,000.0	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,000.0	-
210201	Тэтгэврийн даатгал	90,000.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	2,801,000.0	5,597,000.0
210401	Бичиг хэрэг		94,100.0
210402	Тээвэр, шатахуун	2,801,000.0	5,502,900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	820,000.0	5,665,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,101,000.0
210602	Тавилга		3,564,000.0
210604	Урсгал засвар	820,000.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		57,489,150.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		57,489,150.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,017,270.0	22,531,050.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,566,900.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,017,270.0	18,964,150.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,582,270.0	91,282,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,582,270.0	91,282,200.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,760,000.0	65,313,800.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		16,289,200.0

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,822,270.0	9,679,200.0
131106	Төсвийн урамшуулал		-
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөгжил политехник коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хоол хүнсний зардлын зарцуулалт, томилолтын зардалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Аззаяа 2022 оны 02 дугаар сарын 19-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөгжил политехник коллеж нь “Багшийн хөгжилд тулгуурлан дэвшилтэт техник, технологийг сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэн ур чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага болно.” гэсэн эрхэм зорилтыг дэвшүүлэн иргэнд техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, ажил олгогч, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвар олгох, хөдөлмөрийн болон харилцааны соёлыг төлөвшүүлэх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллажээ:

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль холбогдох бусад хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны тогтоол, шийдвэр, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, төлөвлөгөө, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд 2021 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган үр дүнг тооцон ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ХНХЯ-наас хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжил политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлын 3747.4 төгрөгөөс 1 хувиар тооцон 37.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөгжил политехник коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 370.8 сая төгрөгөөр буюу 94.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Өмнөх оны байгууллагаас авах 2020 онд тэтгэвэрт гарсан ажилтны тэтгэврийн зөрүү болох 5.8 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага болох 3.2 сая төгрөг барагдаж, үлдэгдэл 52.7 сая төгрөгийн барагдуулах арга хэмжээ авч шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэнээр авлага барагдаагүй байна.

Ажилчидтай холбоотой болон байгууллага хувь хүмүүсийн өглөг болох 6.7 сая төгрөгийн авлагыг барагдуулан тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 105.7 сая төгрөг болж 6.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 20.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр, 265.5 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч 301.3 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 8 619.1 сая төгрөг, оны эцэст 9 616.4 сая төгрөг болж 997.3 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 9.3 сая төгрөг, үнэ төлбөргүйгээр 991.7 сая төгрөгийн хөрөнгийг төсөл хөтөлбөр болон өөрийн хөрөнгө, дотуур байрны их засварын сайжруулалт хийгдэж, Төрийн өмчийн хорооны шийдвэрээр 71.6 сая төгрөгийн данс ангилал хооронд шилжүүлж авсантай холбоотой байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн дансны оны эхний үлдэгдэл 6 129.4 сая төгрөг байсан оны эцэст 6 506.1 сая төгрөг болж тайлант онд 376.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн дансны өөрчлөлтийн нөлөөлөл байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөгжил политехник коллежийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,703.2 сая төгрөгөөр, өөрийн орлогоор 36.0 сая төгрөг, нийт 3,739.2 сая төгрөг, нийт зарлагыг 3,739.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хөдөлмөр нийгэм хамгааллын яамнаас тус байгууллагын төсвийг 3,041.9 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 3,041.9 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Тодотголоор 2,994.3 сая төгрөг болгон баталсан байна. Анх баталсан төсвөөр Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор 304.2 сая төгрөг хэмнэхээр байсан ч тодотгосон төсөв төвлөрүүлсэн үлдэгдлээр 266.2 сая төгрөг хэмнэж тогтоолын хэрэгжилтийг 38.0 сая төгрөгөөр тасалсан байна. Анх баталсан төсвөөс 38.0 сая төгрөгийн хэмнэлт дутуу үүссэн шалтгааныг 960 хүүхдийн шинэ сургууль ашиглалтад орсонтой холбоотой хэмнэж болох зардлууд зайлшгүй шалтгааны улмаас хэмнэгдээгүй гэсэн 27 тоот албан тайлбар ирүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,958.1 сая төгрөг, өөрийн орлогоор 36.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,984.8 сая төгрөгийг зарцуулж 9.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны тайлангаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 16.3 сая төгрөг, төсөл хөтөлбөр болон сургуулийн багш, ажилчид, суралцагчдаас 65.3 сая төгрөг, өөрийн орлогоор 9.6 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 91.3 сая төгрөг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 149 мэдээллийг хугацаандаа оруулсан, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12 ажил гүйлгээг шилэн дансны сайтад байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гарган хэрэгжилтийг хангахаар ажилласан ч шүүхийн шийдвэрийн улмаас бүрэн хэрэгжээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар оюутны дотуур байрны хоол хүнсний зарцуулалт, хичээл практикийн зардлын зардлын зарцуулалттай холбоотой асуудлыг авч үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,851.8 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 4,785.3 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 52.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд: 960 хүүхдийн шинэ байр ашиглалтад орсонтойгоор санхүүжилтийн гүйцэтгэл дутуу, дээд шатны байгууллагаас үндсэн хөрөнгөд бүртгэхгүй гэсэн чиглэл ирсэн тул үндсэн хөрөнгөөс 4,765.6 сая төгрөгөөр бууруулж, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлыг буруу тооцсонтой холбоотой 19.7 бууруулж нийт 4,785.3 сая төгрөгийг залрууллаа.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын 2022 оны 2 сарын 28-ны өдрийн 26 тоот албан тоотой залруулсан болно.

4.2 Албан шаардлага

Өмнөх онд авлага барагдуулах талаар хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжийн дагуу Хөгжил политехник коллежоос Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч “хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” 153/ШТ2021/00061 дугаартай шүүхийн тогтоол гарч тогтоолын үндэслэх хэсэгт “...захирал нь байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд байх тул ...хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.”

“...учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр тухайн байгууллагын дээд шатны байгууллага болох Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дотоод аудитын нэгж, дотоод аудитын нэгж байхгүй бол төрийн аудитын байгууллага тус байгууллагыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг дурдах нь зүйтэй.” гэжээ. Тус тогтоолын дагуу Хөгжил политехник коллежоос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт 2021.10.15-ны 324 тоот албан бичгээр хандсан боловч уг авлагатай холбоотой ямар нэгэн хариу ирүүлээгүй, шийдвэрлэгдээгүй тул авлага дансанд бүртгэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хоол хүнсний зарцуулалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Оюутны дотуур байрны хоол хүнсний зардлаас малчин ангийн суралцагсад хоол хийж үйлчлэхээр 3 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгжүүдийн гэрээ дүгнэсэн акт байхгүй, ажил гүйцэтгэлийн анхан шатны баримт хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.1 Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод хяналтын баг томилон малчин ангийн зардалд хяналт хэрэгжүүлэн, хоол хүнсний зардлыг бусад зардалд гүйлгэн зарцуулахгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Албан томилолттой холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд багш ажилчдад томилолтын зардал олгохдоо томилолтоор ажилласан тайлан илтгэх хуудас бичүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Томилолтоор ажилласан ажилчдаар томилолтын тайлан, илтгэх хуудас бичүүлж анхан шатны баримтыг үндэслэн томилолтын зардлыг олгож хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөгжил политехник коллеж	5	4,851.8	2	4,785.3	0	0	1	52.7	2	13.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АУДИТОР:

Ц.АЗЗАЯА